



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН
ЦЭВЭР АГААРЫН САН

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
4-р хороо, Бага тойруу 15,
Нийслэлийн Засаг Захиргааны IV байр,
Утас: 321873, Факс: 976-11-321876
E-mail: info@caf.mn

2015. 05. 26 № 1/71
танай _____ -ны № _____ -т

Г МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
АСУУДЛЫН ДЭД ХОРООНД

Монгол Улсын Засгийн газрын Тусгай сан – Цэвэр агаарын сангийн 2014-2015 онуудын үйл ажиллагааны тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 33 хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БААСАН



**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН - ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН
2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2015 оны 02 дугаар сарын 05
Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын тусгай сан – Цэвэр агаарын сан (цаашид “ЦАС” гэх)-ийн үйл ажиллагаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12¹.2-т заасны дагуу агаарын бохирдлыг бууруулахад чиглэгдсэн олон төрлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж ажиллахаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаал шийдвэрийг үндэслэдэг.

ЦАС-ийн 2014 оны төсвийн төлөвлөгөөг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо (цаашид “АББҮХ” гэх) үйл ажиллагаа нэг бүрээр хэлэлцэж үүрэг, чиглэл өгсөний дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн A-93 дугаар тушаалаар баталсан. Явцын дунд үйл ажиллагааны хэрэгжилт болон Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалга саналд тулгуурлан 2014 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр ЦАС-ийн Удирдах зөвлөл хуралдаж тус сангийн 2014 оны төсвийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсаныг БОНХ-ийн Сайд 2014 оны A-314 дүгээр тушаалаар баталсан.

2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ЦАС-ийн Удирдах зөвлөл дахин хуралдаж 2014 оны урьдчилсан тайланг хэлэлцээд үлдэж байгаа хугацааны санхүүжилтийн төлөв байдалд дүн шинжилгээ хийснээс гадна зарим нэгэн байгууллагаас ирүүлсэн санал хүсэлтийг харгалзан ЦАС-ийн 2014 оны төсвийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсаныг БОНХ-ийн Сайд 2014 оны A-430 дугаар тушаалаар баталгаажуулсан болно.

2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн төсвийн тодотголоор ЦАС-ийн 2014 оны төсвийг 15 тэрбум 260,85 сая төгрөг болгон бууруулсан. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Санхүү, эдийн засгийн хэлтсээс 2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр ЦАС-ийн санхүүд цахим шуудангаар мэдэгдэхдээ 2014 оны санхүүгийн тайландаа төсвийн тодотголыг тусгахыг анхааруулсны дагуу энэхүү тайланг гаргаж байна.



ЦАС-ИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ

д/д	Үйл ажиллагын үндсэн чиглэл	Төсөвлөсөн дүн /сая төг/	Зардлын дүн /сая төг/
1	Гэр хорооллын иргэдийг сайжруулсан түлшээр хангах, түлш тээвэр, борлуулалтын зардал	2557,49	185,994
2	Гэр хорооллын иргэдийг сайжруулсан зуухаар хангахад татаас, борлуулалтын зардал	7049,56	4504,53
3	Хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх	1500,0	1465,16
4	Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэд, олон нийтийн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, аймаг орон нутагт агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх	187,5	117,77
5	Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, дулаалтын сайжруулах, сэргээгдэх эрчим хүч, цэвэр технологийг хөгжүүлэх, үүний дотор халаалтын зуухны шинэчлэл, төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн шугам сүлжээ	2040,64	1275,05
6	Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн олон нийтэд мэдлэг олгох сургалт сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах	298,13	236,392
7	Агаарын чанарын хяналт, шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, агаарын чанарын төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг тогтоо болон агаарыг хамгаалахтай холбогдолтой стандарт, норм дүрэм, арга аргачлал боловсруулах, судалгаа шинжилгээний төсөл гүйцэтгэх	1297,53	1221,74
8	Цэвэр агаарын сангийн дотоод зардал	330,0	179,25
НИЙТ		15260,85	9185,89
Жич: Төрийн санд эргэн төвлөрүүлсэн хөрөнгө /Иргээс төлсөн төлбөр болон гэрээ дүгнэсэн актаар суутгасан/			439,1
Барьцаа хөрөнгийн дансанд түр байршуулсан			242,34

Цэвэр агаарын сангийн 2014 оны төсвийн төлөвлөлт болон төлөвлөгөөний дагуу гаргасан санхүүжилтийн байдлыг дэлгэрэнгүй хүснэгтээр харуулав.

д/д	ЗАРДЛЫН НЭР, ТӨРӨЛ	Төсөв-лөсөн /сая төг/	Гэрээ хийсэн /сая төг/	Санхүүжүүлсэн /сая төг/	Захиалагч	Тайлбар
A	Б	В	Г	Д	Е	Ё
1	Гэр хорооллын айл өрхийг сайжруулсан коксон ба нүүрсэн шахмал түлшээр хангах зорилгоор нөөц бүрдүүлэх, түүнийг санхүүжүүлэх	850,0	850,0	34,26	Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо	"Шарын гол энерго" ХХК 28,8 сая, "Баялаг эрдэнэ цом" ХХК 5,4 сая



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН
ЦЭВЭР АГААРЫН САН**

A	B	C	D	E	F
2	Сайжруулсан шахмал түлшний шинжилгээний зардал	20,0	0,0	0,0	Нийслэлийн АЧА Гэрээ байгуулаагүй
3	Сайжруулсан шахмал түлш борлууллагчийн зардал /тээвэр, агуулах, борлуулалт/	1550,0	гүйцэтгэлээр	16,38	АББҮХ "Агмарко" ХХК-тай гэрээ 1 тн тутамд 25500
4	Үртсэн шахмал түлш нөөцлөх агуулах түрээслэх зардал	0,9	-	0,89	Нийслэлийн ЗДТГ 2013 оны үлдэгдэл санхүүжилт
5	Үртсэн шахмал түлш тээвэрлэх зардал	5,68	гүйцэтгэлээр	5,34	АББҮХ НАЧА "Эм жи эл эс би ди" ХХК
6	Түлш борлуулах хэсгийн ахлагч нарын цалин, гэрээт борлуулагчдын урамшуулал	106,05	гүйцэтгэлээр	104,26	НАЧА-д 94 сая, "Эм жи эл эс би ди" ХХК 9,9 сая
7	Гэр хорооллын айл өрхийг боловсруулсан үртсэн шахмал түлшээр хангах зорилгоор нөөц бүрдүүлэх, санхүүжүүлэх	24,86	-	24,86	Нийслэлийн ЗДТГ 2013 оны үлдэгдэл санхүүжилт /НӨҮГ-т/
		2557,49		185,994	
8	Гэр хорооллын айлуудыг сайжруулсан зуухаар хангахад татаас	6734,48	гүйцэтгэлээр	4389,0	НЗДТГ-ын захиалгаар "УБ-Цэвэр агаар" төсөлтэй хамтран Их тэнгэрийн хүч 152,1 сая, Роял өүшн 2,8 тэрбум, Том хорол 5,2 сая Ханбаян 0,14 сая Сэлэнгэ констракшн 1,14 тэрбум, Хүрд 186,87 сая, Роял өүшн /2013/ 130,4 сая
9	Налайх, Багануур дүүргийн гэр хорооллын 9000 орчим өрхөд зуух нийлүүлсэн түгээлтийн зардал	15,58	гүйцэтгэлээр	15,53	НЗДТГ "Роял өүшн" ХХК
10	Гэр цэгүүдийн борлуулалттай холбогдон гарах зардал /"Хасбанк" ХХК/	299,5	гүйцэтгэлээр	100,0	НЗДТГ 2013 оны гэрээтэй
		7049,56		4504,53	
11	Хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг дэмжих	1500,0	1494,9	1465,16	АББҮХ Дашваанжил 349,9 сая, Горгаз 350 сая, Юнигаз 346,5 сая
		1500,0		1465,16	
12	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих	100,0	60,27	30,27	АББҮХ, БОНХЯ БОНХЯ-аас шалгаруулсан 6 ААН-тэй гэрээтэй
13	Аймаг орон нутагт агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх	87,5	87,5	87,5	АББҮХ, ЦАС 2013 оны зарцуулаагүй санхүүжилт



A	Б	В	Г	Д	Е	Ё
		387,5		117,77		
14	ҮБ хотын захын хорооллын нам даралтын зуухнуудыг татан буулгаж, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох	138,9	-	91,98	Батлан хамгаалах яам	2013 оны гэрээт ажил. "Жаргал констракшн" ХХК
15	ҮБ хотын захын хорооллын сургууль, цэцэрлэгийн халаалтын зуухнуудыг татан буулгаж, төвлөрсөн дулаанд холбох	500,0	114,93	100,5	НЗДТГ	"Яруу Ус" ХХК, "Зууны сод хийц" ХХК 2 гэрээ
16	Агаарын чанарыг сайжруулах бүсэд айл өрхийг цахилгаа-наар халаах боломж нэмэгдүүлэхийн тулд цахилгаан хангамж сайжруулах	1090,0	1055,37	954,04	НЗДТГ	11 компанийн гэрээтэй. ЧД, СБД, БЗД-т ажил хийгдэнэ.
17	Цагаан даваа, Цагдаагийн академи, УС-15 орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох	70,15	-	0,0	НЗДТГ	2011-2012 оны гэрээт ажил. "Набсан" ХХК
18	Автомашин хийгээр цэнэглэх зөөврийн станц байгуулах	12,88	-	0,0	БОНХЯ	2012 оны гэрээ ДашваанжилХХК
19	Дэнжийн 1000 орчмыг төвлөрсөн дулаан хангамжид холбох эхний ээлжийн ажил	228,7	-	128,53	НЗДТГ	2012 оны гэрээт ажил. "Хүрд" ХК
		2040,64		1275,05		
20	Олон нийтэд сургалт, сурталчилгаа хийх, агаарын бохирдлын хэмжээ төлөв байдлыг өдөр тутам нийтэд мэдээлэх, асуудал дэвшиүүлсэн мэдээлэл гаргах	268,7	245,0	212,46	АББҮХ, БОНХЯ	2013 оны гэрээгээр 23,7 сая төг олгов. 2014 онд 245 сая төгийн гэрээтэй
21	Сайжруулсан зуухны зөв галлагааны талаар сурталчлах материал хэвлүүлэх	5,0	5,0	5,0	ЦАС	Гэр хороололд үнэгүй тараах комик ном
22	Автотээврийн хэрэгслээс гарах агаарын бохирдлыг бууруулах, шинэ технологи нэвтрүүлэх, ТВ сурталчилгаа	24,43	-	18,93	Зам тээврийн яам	Ягаан сувд ХХК. 2013 оны гэрээ Алданги 5,5 сая ₮ суутгасан
		298,13		236,392		
23	Хот суурин газрын агаарын бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн судалгаа	27,72	-	27,72	БОНХЯ	2012 оны гэрээт ажил. Нийгмийн эрүүл мэндийн сургууль
24	ҮБ хотын агаарын бохирдлыг бууруулахад нөлөөллийн үнэлгээ ба прогнозчлолын математик загварчлал	30,0	30,0	30,0	БОНХЯ	МУИС-ийн Математикийн хүрээлэн



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН
ЦЭВЭР АГААРЫН САН**

A	B	V	Г	Д	E	Ё
25	Автотээврийн хэрэгслээс гарах агаарын бохирдолтой холбоотой хуулиуд орчуулах, бохирдуулагч бодис, хүнд метал тодорхойлох стандарт нутагшуулах	14,21	-	14,21	Зам тээврийн яам	2013 оны гэрээ ШУТИС.Механик инженерийн сургууль /12 стандарт/
26	Агаар дахь бохирдуулах бодис, хүнд метал тодорхойлох багаж, дагалдах хэрэгслийн хамт	415,6	415,6	415,6	ЦУОШГ	2013 оны гэрээ "Түшиг цамхаг" ХХК
27	Шинэ техник, технологи, инновацийг турших, дүгнэлт гаргах, судалгаа шинжилгээ, мэргэжлийн зөвлөх баг ажиллуулах	23,5	5,0	6,2	АББҮХ, БОНХЯ	АББҮХ-ны зөвлөх багтай 5 сая-ийн гэрээ БОНХЯ 2,2 сая
28	Ахуйн хэрэглээний зуух. Техникийн ерөнхий шаардлага MNS5216-1:2011, халаалтын болон гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга MNS5457:2007-г шинэчлэх	6,5	0,0	0,0	БОНХЯ	Зардлын задаргaa тодорхойгүй учраас гэрээ байгуулаагүй
29	Циклон буюу үнс баригч үйлдвэрлэх технологи бий болгох, улмаар хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих	50,0	48,9	46,46	АББҮХ	Дулаан техник үйлдвэрийн экологийн хүрээлэн
30	Дамбадаржаад голын эхэнд цөөрөм барьж цэцэрлэгжүүлэх ажлын зураг төсөл	20,0	0,0	0,0	НЗДТГ	Тендерийн баримт ирүүлээгүй тул гэрээ хийгээгүй
31	Агаарын бохирдлын хувь хэмжээг тодорхойлох ухаалаг хяналт	340,0	330,8	330,79	АББҮХ, ЦУОШГ	"Аствишн" ХХК 327,5 сая, ЦУОШГ 3,3 сая
32	Сайжруулсан зуухны хяналт тооллого	341,2	341,2	322,04	АББҮХ	"Эс Ай Си Эй" ХХК
33	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, бүртгэл хөтлөх, хяналт тавих, тооллого хийх ажлыг гүйцэтгэх гэрээт ажилтнуудын цалингийн зардал	28,8	28,7	28,72	АББҮХ	АББҮХ-ны гэрээт ажилчдыг цалинжуулсан
		1297,53		1221,74		
34	Цэвэр агаарын сангийн ажлын албаны дотоод зардал	330,0		179,25	ЦАС	
НИЙТ		15260,8		9185,89		

2014 онд ЦАС-ийн төсөвт нийт **15,26** тэрбум төгрөг төсөвлөгдсөнөөс 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар **9 тэрбум 185,89 сая** төгрөгний санхүүжилт гаргасан. Төрийн сан дахь барьцаа хөрөнгийн дансанд 242,34 сая төгрөг байршуулсан.



САЙЖРУУЛСАН ЗУУХ ТАРААХАД ТАТААС ОЛГОХ АЖИЛ

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2012 оны 12/24-р тогтоол, 2013 оны 13/30, 2013 оны 13/31 дүгээр тогтоолын дагуу нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд сайжруулсан зуух нийлүүлэхэд татаас олгох ажлыг Цэвэр агаарын сан 2014 онд үргэлжлүүлэн санхүүжүүлсэн. Үүнд: Нийслэлийн ЗДТГ-тай хамтран 6248 ш усан халаалтын “Илч” зуухны суурилуултад татаас олгох ажлыг 2012 оны 12 дугаар сараас, Дэлхийн банкны “Улаанбаатар-Цэвэр агаар” төсөлтэй хамтран 45000 ш сайжруулсан зуух тараахад татаас олгох ажлыг 2013 оны 10 дугаар сараас тус тус эхлүүлсэн.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2014 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор зуух нийлүүлэх хуваарийг дахин тодотгох болсонтой холбоотойгоор энэ ажлыг 2014 оны 05 дугаар сарын 30-наар тасалбар болгон зогсоосон. УБ-Цэвэр агаар төслөөс 2013 онд 11424 ш, 2014 оны эхний хагаст 18283 ш, нийт 29707 ш зуух тарааж ЦАС хамтарсан татаас олгосон. АББҮХ-ны 2014 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 6 дугаар тогтоолоор энэ төсөл үргэлжлэн хэрэгжиж үлдсэн 15293 зуухыг тараахад татаас олгохоор гэрээ хийгдсэн.

2014 онд сайжруулсан зуух худалдан авахад татаас олгосон байдал:

	Төсөл хэрэгжүүлэгч	Зуухны нэр, төрөл	2014 онд ний- лүүлсэн зуухны тоо /ширхэг/	2014 онд санхүүжүүлсэн татаас /сая төг/
1	Хүрд ХК	 Усан халаалтын “Илч” зуух (2012 оны гэрээ)	Актаар 1805 (1343 зуухны тайлан баталгаажаагүй)	186,875
2		 “Сэлэнгэ констракшн” ХХК-ий “Өлзий” зуух	5425	1144,455
3	Дэлхийн банкны Улаанбаатар цэвэр агаар төсөл	 Роял өүшн ХХК-ий “Дөл” зуух	12513	2650,13
5		“Голомт” зуух	850	119,68
6		 “Их тэнгэрийн хүч” ХХК-ий “Векас-107” зуух	1104	152,08
7		“Том хорол” ХХК-ий “Чин” зуух	37	5,21
8		“Ханбаян” ХХК-ий “Номин” зуух	1	0,14
9	Роял өүшн ХХК	2012 оны гэрээт 16500 ш Дөл зуухны үлдэгдэл санхүүжилт	2013 оны 373 ш зуухны татаас	130,43
	НИЙТ		21735	4389,0

Жич: “Илч” зуухны нийлүүлэлтийн тайланг Нийслэлийн Агаарын чанарын албаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр холбогдох санхүүжилтийг хийдэг.

2014 онд сайжруулсан зуух авсан иргэдэд Цэвэр агаарын сангаас нийт **4 тэрбум 389 сая төгрөгний татаас олгосон** болно.



САЙЖРУУЛСАН ШАХМАЛ ТҮЛШ

2014 оны эхээр өмнөх онд байгуулсан гэрээний дагуу үртсэн шахмал түлшний үнэ, борлуулалт, хадгалалт, тээврийн зардалд нийт 120 сая төгрөгийн санхүүжилт гаргасан. Үүнээс аэсгийн ахлагч, гэрээт борлуулагчдын урамшуулал 94,3 сая төгрөгийг Нийслэлийн агаарын чанаарын албанад шилжүүлсэн. Үртсэн түлшний татаасанд 24,9 сая төгрөг, агуулахын зардалд 0,9 сая төгрөг тус тус санхүүжүүлсэн. 2011-2013 онуудад АББҮХ-ноос сайжруулсан шахмал түлш худалдан авсан иргэдэд ЦАС-аас татаас олгох шийдвэр гаргаж түлшний үнэ, татаасын хэмжээг тогтоодог байсан. 2014 онд түлшний татаас олголтыг зогсоож иргэд зах зээлийн үнээр нь худалдаж авах, төрөөс борлуулалтын зардлыг санхүүжүүлэх зарчимд шилжсэн.

2014 оны 02 дугаар сард АББҮХ-ны 01 дугаар тогтоолын дагуу “Шарын гол энэrgo” ХХК, “Баялаг эрдэнэ цом” ХХК-иуд нийт 5000 тонн коксон шахмал түлш нийлүүлэх гэрээ байгуулсан боловч гүйцэтгэлээр 329,12 тонн түлш нийлүүлсэн. Түлш худалдан авсан иргэдийн төлсөн 38,3 сая төгрөгийг Төрийн санд бүрэн төвлөрүүлсэн. Борлогдоогүй үлдсэн 104,1 тонн түлшийг агуулахад хадгалж байгаад галлагааны улирал эхлэхэд борлуулах арга хэмжээ авсан.

АББҮХ-ны 2014 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сайжруулсан түлш нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдээс нийлүүлсэн түлшний хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын зардлыг ЦАС-аас санхүүжүүлэх шийдвэр гарсаны дагуу АББҮХ-ны ажлын алба хариуцан түлш үйлдвэрлэгч “МАК” ХХК болон борлуулагч “Агмарко” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулсан. 2014-2015 оны галлагааны улиралд “Агмарко” ХХК нийт 31 борлуулалтын цэг ажиллаж сайжруулсан шахмал түлш иргэдэд борлуулж байна. Тус компанийд 642,4 тонн сайжруулсан түлшийг борлуулсны зардалд 16,38 сая төгрөг олгоод байна.



Төмөр замын өртөөн дээр түлш хүлээн авч автомашинаар тээвэрлэж дундын агуулах руу эсхүл борлуулалтын цэгт шууд хүргэнэ.


АББҮХ-ны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 7 дугаар тогтоолоор гэр хорооллын айл өрхүүдэд эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан гал ноцоогч нийлүүлэх гэрээ байгуулахыг тус хорооны ажлын албанад, санхүүжүүлэхийг ЦАС-д даалгасан боловч шалгарсан аж ахуйн нэгжүүд төлбөрийн баталгаа ирүүлэх чадамжгүй шалтгаанаар ЦАС гэрээ байгуулах боломжгүй болсон.




ХИЙН ТҮЛШНИЙ ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ

АББҮХ-ноос өгсөн үүрэг даалгаврын дагуу тус хорооны ажлын алба тендер зарлаж шингэрүүлсэн хийн түлшний хангамжийг нэмэгдүүлэх, нөөцлөх, хадгалах агуулахыг өргөтгөх, гэр хорооллын хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор хийн тоног төхөөрөмж нийлүүлэх тухай гэрээг “Дашваанжил” ХХК, “Горгаз” ХХК, “Юнигаз” ХХК зэрэг гурван аж ахуйн нэгжтэй нийт 1 тэрбум 494,9 сая төгрөгийн дүнтэйгээр байгуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд Цэвэр агаарын сан санхүүжилтийн гэрээ байгуулан үе шаттайгаар санхүүжүүлэх үүрэг хүлээсэн. Энэхүү гэрээний хүрээнд компани тус бүр 200 м³-ээс багагүй багтаамжтай хий хадгалах агуулах байгуулж ашиглалтад оруулах, гэр хорооллын 1625 айлд хийн плитка, баллоны иж бүрдэл төхөөрөмж нийлүүлж суурилуулах үүрэг хүлээсэн.


2014.12.31-ний байдлаар 3 компаний хийн агуулахын ажлууд дуусах шатандаа орсон. Үүнээс “Юнигаз” ХХК ажлаа бүрэн дуусгасан байна. Бусад байгууллагуудын гүйцэтгэл ойролцоогоор 95 % байна.




“Юнигаз” ХХК-ий агуулах




Хий цэнэглэх байгууламж




“Дашваанжил” ХХК-ий агуулах



Компрессорууд




“Горгаз” ХХК-ий агуулах




Компрессор


Хийн плитка баллоны иж бүрдэл суурилуулах ажлын хувьд 2014.12.25-ны байдлаар “Юнигаз” ХХК 1553 ш, “Дашваанжил” ХХК 1553 ш, “Горгаз” ХХК 1543 ш төхөөрөмж гэр хорооллын айлуудад суурилуулсан дүнтэй байна.



“Горгаз” ХХК-ий плитка



“Юнигаз” ХХК-ий плитка



“Дашваанжил” ХХК-ий плитка

ДУЛААН ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР



Өвлийн улиралд их хэмжээний нүүрс түлж өвөлждөг байсан захын хорооллын халаалтын зуухнуудыг шинэчлэх, хэрэглэгчдийг дулаан хангамжийн шугам сүлжээнд холбох чиглэлээр 2014 онд нийт 1,24 тэрбум төгрөг төсөвлөсөн. Үүний 800 сая төгрөг нь 2014 онд шинээр хэрэгжүүлэх ажлын төсөв юм.

Нийслэлийн Засаг даргын 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн A/549 дүгээр захирамжаар Баянгол дүүргийн 113 дугаар сургуулийн гадна дулааны шугам, 11-р Ус дулаан дамжуулах төвийн 2-р контурын салаа шугамын өргөтгөл, Чингэлтэй дүүргийн 39-р сургуулийн дотор дулаан хангамжийн шугам сүлжээ, 39-р сургууль, 10-р хорооны цогцолбор барилга, 124-р цэцэрлэгийг төвийн дулаан хангамжид холбох зэрэг нийт 762,67 сая төгрөгийн төсөвт ажлыг Цэвэр агаарын сангийн хөрөнгөөр гүйцэтгэж ашиглалтад оруулахыг холбогдох этгээдүүдэд үүрэг болгосон.


Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулалт оройтох зарлагдсан, энэхүү ажил хүйтний улиралд хэрэгжих боломжгүй болсон шалтгаанаар 2 ажил дараа онд шилжиж 113-р сургуулийн гадна дулаан, 39-р сургуулийн дотор дулаан хангамжийн ажлуудыг санхүүжүүлсэн.



Гүйцэтгэгч "Яруу Ус" ХХК, "Зууны сод хийц" ХХК-иудад 100,5 сая төгрөг олгож барьцаа хөрөнгийн дансанд 3,8 сая төгрөг байршуулсан.





БГД-ийн 113 дугаар сургууль, сургуулийн гадна шинээр хийсэн дулааны худаг



ЧД-ийн 39 дүгээр сургууль, ангиудад шинээр угсарсан халаалтын радиатор

Өнгөрсөн онд Зэвсэгт хүчний 015, 310 дугаар ангиудын халаалтын зуухны барилга барьж, шинээр зуух суурилуулан, орчмын хэрэглэгчдийг дулаанаар хангах төслийн хүрээнд байгуулсан гэрээнүүдийн үлдэгдэл санхүүжилт 91,98 сая төгрөгийг 2014 онд олгосон. Барьцаа дансанд 31,75 сая төгрөг байршуулсан.






ЗХ-ний 015 дугаар ангийн зуухны барилга /хуучин, шинэ/, суурилуулсан зуух /1,44мВт/



ГЭР ХОРООЛЛЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ


АББҮХ-ны 2014 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолоор нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн айл өрхүүд цахилгаан халаагуур хэрэглэх нөхцөлийг нэмэгдүүлэх, хэт ачаалагдсан дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамын ачааллыг хөнгөлөх, шинэчлэх ажлыг зохион байгуулж Цэвэр агаарын сангаас санхүүжүүлэхийг даалгасан. Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/859 дугаарт захирамж батлагдаж 11 байрлалд дэд станцын ачааллыг хөнгөлөх, ЦДАШ-ыг шинээр угсрах, эсхүл 2 хэлхээт болгох зэрэг ажлуудыг ЦАС-ийн хөрөнгөөр гүйцэтгэхийг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт даалгасан тул Цэвэр агаарын сан, НХОГ, гүйцэтгэгч 11 ААНБ-уудтай нийт 1 тэрбум 55 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээнүүдийг байгуулсан.

Энэ төслийн ажил бүрэн дуусч улсын комисс хүлээн авсан бөгөөд ЦАС-аас 954 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна. Барьцаа дансанд 78,98 сая төгрөг байршуулсаныг ашиглагч байгууллагын тодорхойлолтоор 2015 онд олгоно.



250 кВА хүртэл хүчин чадалтай АТП, 0,4 кВт-ын щит, 1 фазын 6-аар багцалсан тоолуурууд



Энэ төслийн хүрээнд нийслэлийн 3 дүүргийн нутаг дэвсгэрт 11 байрлалд 250 кВА хүртэл хүчин чадалтай АТП хоёр, 160 кВА хүртэл хүчин чадалтай АТП хоёр, 250 кВА хүртэл хүчин чадалтай КТПН гурвыг суурилуулсан.



Тасган фидерийн шинэ АТП



Сурагч фидерийн шинэ АТП



Умард фидерийн 250 кВА хүртэл хүчин чадалтай КТПН


АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧАДАВХИ БЭХХЖҮҮЛЭХ, СТАНДАРТ, НОРМ ДҮРЭМ, АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

1. Зам тээврийн яамны захиалгаар 2013 онд байгуулсан гэрээний дагуу Олон улсын стандартын байгууллага (ISO)-аас баталсан Хүрээлэн байгаа орчин, эрүүл мэндийн хамгаалал. Агаарын чанарын болон бохирдолтой холбоотой стандартыг нутагшуулах ажлын хүрээнд ШУТИС-ийн Механик инженерийн сургуулиас нийт 12 стандарт боловсруулж Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 11 дүгээр тогтоолоор батлуулсан. Ингэснээр автомашинаас ялгарах утааны хий дэх хорт бодисыг хэмжих багаж, арга аргачлал, оношлохтой холбоотой шинэ стандартуудтай болсон.

2. АББҮХ-ны 2014 оны 02 дугаар 17-ны өдрийн 02 дугаар тогтоолын 3-т заасны дагуу тус хорооны ажлын албаны дэргэд эрдэмтдийн зөвлөх баг байгуулагдан гэр хорооплын айл өрхүүдийн энгийн болон нам даралтын зууханд хэрэглэх утаа багатай антрацит нүүрсэнд лабораторийн туршилт хийх, нүүрс түлшийг хурдан асаах зориулалт бүхий бүтээгдэхүүний туршилтыг тус тус хийж дүгнэлт гаргасан. Энэ ажлыг ЦАС-аас 4 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.

3. АББҮХ-ны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 7 дугаар тогтоолын дагуу бага болон дунд чадлын халаалтын зуухнаас гарч байгаа бохирдлыг бууруулах ажлын хүрээнд циклон буюу үнс баригч үйлдвэрлэх технологи бий болгох, улмаар хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг Цэвэр агаарын сангаас гаргахыг үүрэг болгосон. Үүний дагуу АББҮХ-ны Ажлын албанаас тендер зарлаж Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэнтэй 50 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж ЦАС 46,45 сая төгрөгөөр санхүүжүүлж барьцаа хөрөнгийн дансанд 2,45 сая төгрөг байршуулсан.

Тус хүрээлэнгийн инженерүүд 40 хүртэл кВт, 80 кВт, 120-250 кВт, 300 кВт-аас дээш хүчин чадалтай зуухнуудад тохирох үнс утаа баригч циклонуудыг өөрсдийн хүчээр зохион бүтээжээ.



Туршилтаар хагас портер Налайхын нүүрс шатаахад 4,1 кг тортог тоосонцор циклонд баригдаж үлдсэн байна.



Мөн төслийн инженерүүд циклоны ажиллагааны математик загварчлалыг боловсруулжээ.

Бага дунд хүчин чадалтай зууханд тохирох 2 циклоныг одоо ажиллаж байгаа халаалтын зуухнуудад суурилуулан туршиж байгаа. Туршилтаар циклоны ашигт үйлийн коэффициент 80-88% байна гэсэн дүгнэлт гарсан. Дахин 2 циклоныг 100 кВт-аас дээш хүчин чадалтай зууханд суурилуулж 2014-2015 оны халаалтын улиралд багтаан туршилтын дүгнэлт гаргана.

Мөн энэхүү төслийн хүрээнд нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа халаалтын зуухны галч нарт сургалт явуулж сертификат олгож эхэлсэн. 2014 оны 12 дугаар сарын эцэс гэхэд нийт 123 галч сургалтанд хамрагдаж 71 нь сертификат авсан. Нэг удаагийн сургалт 34 кредит цагийн хөтөлбөртэй.

БУСАД АЖЛУУД

Нэг. АББҮХ-ны 2014 оны 02 дугаар 17-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Агаарын чанарын ухаалаг хяналтын систем бий болгох, хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлэхийг холбогдох этгээдүүдэд үүрэг болгосны дагуу тус хорооны ажлын алба тендер шалгаруулж "Аствишн" ХХК-тай 327,5 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулан Цэвэр агаарын сангаас санхүүжүүлсэн. Энэ төслийн хүрээнд зуухны хяналтын систем /вэб програм/, Android болон Apple үйлдлийн системтэй гар утаснаас хэрэглэх боломжтой мобайл appliceshn болон агаарын чанарыг олон нийтэд мэдээлэх систем /вэб програм/, хянах самбар /энэ вэб програмд зөвхөн шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд нэвтрэх эрхтэй/ зохиосон. Эдгээрээс гадна нийслэлийн агаарын чанарын 10 суурин харуулуудын ойролцоо ЛЭД дэлгэцүүд байрлуулан харуулын хэмжилтийн үр дүн шууд дэлгэцэн дээр харагдаг байхаар суурилуулсан.




Агаарын чанарыг олон нийтэд мэдээлэх систем


“Агаарын чанарын ухаалаг систем”-ийг нэвтрүүлснээр тухайн орчных нь агаарын бохирдол ямар түвшинд байгааг иргэд шууд харах боломж бүрдүүлэх, энэ чиглэлээр явагдаж байгаа үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах, нөгөөтэйгүүр төрийн байгууллагууд хийж буй ажлаа нэгдсэн мэдээллийн нэгдсэн сангаас харж дүгнэх нөхцөл бүрдсэн. Agaar.mn вэб сайт, гар утасны апликэшн, гудамжинд байрлах LED дэлгэцийг хослуулсан цогц ухаалаг систем 30 минут тутамд агаарын чанарын мэдээллийг шинэчлэн олон нийтэд хүргэх юм.



Агаарын чанарын суурин
харуул



Амгалан дахь ЛЭД дэлгэц





Хамгийн чадлыгийн
Улаанбаатар, Чингэлтэй, 13, СҮР28, 573A
Адм. Эжүү
Сум Дүүрэг
Улаанбаатар ✓ Чингэлтэй ✓
Баг Хороо
13
Бадр Түүдээж
СҮР28

Гар утасны апликешн

Хоёр. АББҮХ-ны 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолын дагуу тус хорооны ажлын алба тендер зарлаж агаарын чанарын ухаалаг хяналтын системийн агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, бүртгэл хөтлөх, хяналт тавих, тооллого хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж “Эс Ай Си Эй” ХХК-тай 341,18 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулсан. АББҮХ-ноос даалгасны дагуу ЦАС санхүүжилтийн гэрээ байгуулан 322,04 сая төгрөгийн санхүүжилтийг үе шаттайгаар олгосон. Үлдэгдэл 19,14 сая төгрөгийг “Улаанбаатар-Цэвэр агаар” төслөөр тараагдаж байгаа сайжруулсан зуухны бүртгэл дууссаны дараа олгоно.


Энэ төслийн хүрээнд нийслэлийн гэр хорооллын бүх утаат өрхийн бүртгэл тооллого /төслийн болон энгийн зуухны мэдээлэл/, 11-100 кВт хүртэл хүчин чадалтай халаалтын зуухны бүртгэл тооллого /айл өрх, албан байгууллагаар/, 100 кВт-аас дээш хүчин чадалтай зуух ашигладаг байгууллагуудын бүртгэл тооллого, эцэст нь цахилгаан дулааны станцуудын бүртгэл тоолого гэсэн хэд хэдэн хэсгээс бүрдэх ажил гүйцэтгэн



“Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн бүртгэл, тооллого - 2014”, “Улаанбаатар хотын гэр хорооллын өрхүүдийн зуух, түлшний хэрэглээний судалгаа” гэсэн хоёр ном гаргасан.



Тооллогоор нийт утаат өрхийн 55,5 % нь сайжруулсан зуухтай, 44,5 % нь энгийн зуухтай, нийт сайжруулсан зуухны 46 % нь Дөл зуух, 38 % нь Өлзий зуух, 8 % нь Хас зуух, 8 % нь бусад төрлийн зуух байна гэсэн дүн гарчээ. 11-100 кВт хүчин чадалтай зуух нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд 3017, 100 кВт-аас дээш хүчин чадалтай зуух 329 ш, цахилгаан станц 3 байна.




Гурав. Цаг уур, орчны шинжилгээний газрын захиалгаар тус газрын Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораториид агаарын чанаарын хяналт шинжилгээний 3 төрлийн 8 иж бүрдэл багаж төхөөрөмж нийлүүлэх ажлыг 415,6 сая төгрөгөөр санхүүжүүлж “Түшиг цамхаг” ХХК гүйцэтгэсэн. Үүнд:



PM2,5, PM10 хэмжих зөөврийн 4 ш DustTrak/
/87,3 сая



Agaar, ус, хөрсний сорьцонд ионы агууламж тодорхойлох иж бүрэн ионы хроматограф 1 ш /144,8 сая/



Суурин харуул дээр PM2,5, PM10 хэмжих VAM-1020 багаж 3ш /183,5 сая/



DustTrak нь овор багатай, зэөврийн багаж бөгөөд үүний тусламжтайгаар нийслэл, хөдөө орон нутаг, хүнд хөнгөн үйлдвэрүүд, уул уурхайн хаана ч агаар дахь нарийн болон том ширхэглэлт тоосонцрын агуулгыг лазер сарнилын фотометрийн аргаар шууд хэмжиж болдог.

BAM-1020 иж бүрэн багаж нь суурин харуул дээр суурилуулагдаж тодорхой цаг хугацааны давтамжтайгаар агаарын тоосонцрыг Beta ray туюаны тусламжтайгаар хэмжиж гарсан үзүүлэлтүүдэд автоматаар анализ хийдэг. Дотоод санах ой нь тасралтгүй 182 хоногийн өгөгдөл мэдээлэл хадгалах боломжтой.

Герман улсад үйлдвэрлэгдсэн ионы хроматограф багаж нь хүчиллэг тунадасны сорьцонд агуулагдаж байгаа шүлтийн метал, химийн нэгдэл, элементүүдийг ионы түвшинд тодорхойлдог, бие даасан програм хангамжтай, автомат удирдлагатай иж бүрэн төхөөрөмж юм. Түлшний дутуу шаталтаас үүсдэг угаарын хий, хүхэрлэг хий гэх мэт бохирдуулагчдын нөлөөгөөр хүчиллэг тунадас бий болох бөгөөд манай улс Зүүн Азийн хүчиллэг тунадасны хяналт шинжилгээний сүлжээний гишүүн орны хувьд энэ багажийн тусламжтайгаар шинжилгээ хийж хил дамнасан агаарын бохирдол, хүчиллэг тунадасны төлөв байдлыг тогтоо шаардлагатай байдаг юм.

Дөрөв. “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад нөлөөллийн үнэлгээ ба прогнозчлолын математик загварчлал” зөвлөх үйлчилгээний гэрээг БОНХЯ-ны захиалгаар МУИС-ийн Математикийн хүрээлэн 30 сая төгрөгөөр хэрэгжүүлж дууссан бөгөөд төслийн тайланг БОНХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл хэлэлцэж дэмжсэн болно.

Тав. Цэвэр агаарын сангийн 2011-2013 оны үйл ажиллагааны тайланг Үндэсний аудитын газар, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд, 2013 оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг УИХ-ын дарга, Ерөнхий сайд болон БОНХ-ийн сайдад тус тус хүргүүлсэн. Мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс ЦАС-ийн төлөвлөгөө, тайлан, санхүүгийн гүйлгээ, агаарын чанарын болон бусад холбогдох мэдээ мэдээллийг тус сангийн цахим хуудсанд тогтмол байршуулж байна. Мөн УИХ-ын Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо, Үндэсний аудитын газар, Авиалгатай тэмцэх газар болон зарим албан тушаалтуудад шаардсан баримт материалуудыг нь цаг тухайд нь гарган өгч мэдээллээр ханган ажиллаж ирсэн.

Цэвэр агаарын сангийн цахим хаяг

Shilэн данс

Хууль-тогтолцоо АББУХОРОО ЦАС-ийн Удирдаж эрхийн Танд хангийтэй эзэлжэлт Видео сан Үргүйн цомог Холбоо барих

№ САР ТУМЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ

2014 оны 12 дугаар сарын төсвийн зарцуулалт
2014 оны 11 дугаар сарын төсвийн зарцуулалт
2014 оны 10 дугаар сарын төсвийн зарцуулалт
2014 оны 9 дугаар сарын төсвийн зарцуулалт
2014 оны 08 дугаар сарын төсвийн зарцуулалт
2014 оны 07 дугаар сарын төсвийн зарцуулалт
2014 оны 06 дугаар сарын төсвийн зарцуулалт
2014 оны 05 дугаар сарын төсвийн зарцуулалт
2014 оны 04 дугаар сарын төсвийн зарцуулалт
2014 оны 03 дугаар сарын төсвийн зарцуулалт

Видео сан

Мэдээ мэдээлэл

Агаарын чанарын ухаалаг хийнчийн системийн ажиллаж эхлийн

Сайжруулсан




Зургаа. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 309 дүгээр тогтоолоор батлагдсан “Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулалт олгох журам”-ын дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас 6 аж ахуйн нэгжийг шалгаруулсан байна. Тэдгээр аж ахуйн нэгжүүдийг телевизээр сурталчлах, ногоон гэрчилгээ олгох ажилд 2014 оны эцсийн байдлаар 30,27 сая төгрөгийн санхүүжилт гаргаад байна.

Долоо. Өмнөх онд байгуулсан болон одоо хэрэгжиж байгаа гэрээнүүдийн хэрэгжилтийг газар дээр нь шалгах, үр дүнгийн мониторинг хийх, гэрээ дүгнэх, тооцоо нийлэх ажлуудыг тогтмол хийж байна. Тухайлбал:

- Хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, агуулах өргөтгөх ажилд 2 удаа;
- Агаарын чанарын ухаалаг хяналтын систем байгуулах ажилд 1 удаа;
- Сайжруулсан зуух, түлшний нийлүүлэлт, борлуулалтын ажилд тогтмол;
- 113, 39 дүгээр сургуулиудын гадна дотор дулаан хангамжийн шугам сүлжээний ажлуудад тус бүр 1 удаа;
- Халаалтын зуухны яндангаар гарах утаа баригч циклон зохион бүтээх ажилд 1 удаа;
- БЗД, ЧД, СБД-ийн дэд станцуудын ачааллыг хөнгөвчлөх, ЦДАШ-ыг хос хэлхээт болгох зэрэг ажлуудад 1 удаа;
- 2013 оны гэрээтэй захын хорооллын халаалтын зуухнуудыг шинэчлэх, хэрэглэгчдийг төвлөрсөн халаалтад холбох ажлуудад 1 удаа;
- 2013 оны гэрээтэй шалны цахилгаан халаагуурын төслийн хэрэгжилтэд 2 удаа тус тус газар дээр нь хяналт тавьж шалгаж дүгнэсэн.



Хийн агуулах дээр




Гэр хорооллоор явж байгаа нь

Мөн Нийслэлийн агаарын чанарын албанаас хариуцан зохион байгуулсан сайжруулсан зуухны хяналтын тооллогод ЦАС-ийн 4 ажилтан оролцож 2 долоо хоног гэр хороололд ажилласан.



Найм. ЦАС-аас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүдэд холбогдох гэрээ, санхүүгийн баримтууд, ирсэн явуулсан албан бичиг, тушаал шийдвэр, тайлан танилцуулга, акт дүгнэлт зэргийг хуулбарлан электрон хэлбэрт оруулж архивлах ажлыг хийж байна. Энэ ажил ерөнхийдөө дуусах шатандаа явагдаж байгаа бөгөөд цаашдын үйл ажиллагааны бүх баримт мэдээлэл цаасан болон электрон хэлбэрээр архивлагдах болно. 2013 оны сүүлчээс эхлэн архив складын тусгай өрөөнүүдтэй болох ажил зохион байгуулж 2 өрөө бий болгон тохижуулж одоо зориулалтаар нь ашиглаж байна.



Архив складын өрөөнүүд

ДҮГНЭЛТ

Нэг. 2014 онд Цэвэр агаарын сангаас аливаа төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ төсөвт эрсдэл учруулахгүй байх зорилгоор батлагдсан гүйцэтгэлээр санхүүжүүлж ирлээ. Энэ нь өр авлага үүсэхгүй сайн талтай. Өөрөөр хэлбэл өмнөх онуутдай харьцуулахад шинээр үүссэн өр авлага байхгүй болно.

Хоёр. 2014 онд урьд өмнөх онуутдай харьцуулахад санхүүжилтийн процесс харьцангуй удаашралтай явагдсан. Сангийн яамны Төрийн сангийн газарт гүйлгээ тус бүрт санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлт гаргаад сараар хүлээдэг, мөн эрх нээгдсэний дараа шилжүүлэг хийдэг зэргээс шалтгаалж төслийн ажил удаашрах, зогсох тохиолдол гарч байв. Хамгийн удаан saatсан гүйлгээ нь хийн хангамжийг сайжруулах төслийн 597,9 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийн хүсэлтийг 2014 оны 7-р сард гаргахад 300 сая төгрөгийн санхүүжилтийн эрх 10-р сард, 297,9 сая төгрөгийн эрх 12-р сард нээгдсэн жишээтэй. Хэдий тийм боловч Цэвэр агаарын сангийн ажлын алба оны эцэс гэхэд шаардлагат төлбөр тооцог бүрэн барагдуулж чадсан.

Гурав. Цэвэр агаарын сангийн ажлын алба сонирхлын зөрчлөөс сэргийлэх үүднээс нэг ч төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтад захиалагчаар оролцоогүй, нэг ч үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллаагүй. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо болон Нийслэлийн Засаг даргын тамгын газар захиалагчийн хувьд тендерүүдээ шалгаруулж гэрээ байгуулан ЦАС-аас санхүүжүүлсэн. Харамсалтай нь төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт оройтох явдал гарч байсан.



Үүнээс шалтгаалж дулааны улиралд хэрэгжүүлбэл зохих төвлөрсөн дулаан хангамж, цахилгаан эрчим хүчний шугам сүлжээний ажлууд оройтсон. Ялангуяа “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨҮГ-аас галлагааны улирлын дундуур халаалт зогсоох зөвшөөрөл олгоогүй шалтгаанаар зарим хэрэглэгчдийг төвлөрсөн дулаанд холбох ажил 2015 онд хийгдэхээр болж он дамнах жишээтэй.

Дөрөв. Эмнэх жилүүдэд Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд алдаа дутагдал гарсантай холбоотойгоор тус сангийн нэр хүнд ихээхэн унасан байсан. Тийм учраас сангийн бүх гүйлгээг хууль хэрэгжиж эхлэхээс бүтэн жилийн өмнө шилэн дансны зарчимд шилжүүлж цахим хуудсаар олон нийтэд нээлттэй байлгасны үр дүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэд, олон нийт хүссэн мэдээллээ цаг алдалгүй шууд авах боломжтой болж хардлага сэрглэггүй, хандлага нааштай болж байна.

Тав. Цэвэр агаарын сангийн үндсэн ажлын зэрэгцээ ажилтнуудаа ажлын өдөр илүү цагаар, зарим тохиолдолд тохиролцсоны үндсэн дээр амралтын өдөр ажиллуулж тус сангийн бүх гэрээ, санхүүгийн баримт, ирсэн явуулсан албан бичиг, тушаал шийдвэр, тайлан гүйцэтгэл болон бусад баримт бичгүүдийг нэгбүрчлэн сканердаж файл хэлбэрт оруулан электрон архив бий болгож байна. Өмнө нь эрх бүхий этгээд болон хууль хяналтын байгууллагуудад лавлагаа мэдээлэл, баримт материал гаргаж өгөхөд цаас, принтерийн хор, цаг хугацаа маш их шаардагддаг байсан. Энэ ажлыг хэрэгжүүлснээр дээр дурдсан хүндрэлүүд үгүй болно.

Зургаа. 2014 онд төсөвлөсөн 15,26 тэрбумаас 9,186 тэрбумын зарцуулалттай байгаагийн үндсэн шалтгаан нь 1-рт: АББҮХ болон НЗДТГ-аас тендер шалгаруулалтууд оройтож зарлагдсан; 2-рт: АББҮХ-ны шийдвэрээр сайжруулсан зуухны борлуулалтыг зогсоож тооллого явуулсан болон иргэдэд олгож байсан татаасыг бууруулснаас болж Дэлхийн банкны “Улаанбаатар-Цэвэр агаар” төсөлтэй хамтран хэрэгжүүлж байгаа зуухны төслийн борлуулалт багассантай шууд холбоотой. Мөн АББҮХ болон ЦАС-ийн УЗ-ийн хурлаар хэлэлцэгдэж байсан зарим төсөл арга хэмжээ, үр дүнгүй гэж ЦАС-ийн Ажлын алба үзсэнээс санхүүжүүлэхээс татгалзаж байсан. Тухайлбал: гэр хорооллын айлуудад гол ноцоогч нийлүүлэх 200 сая төгрөгийн төсөвт ажил, утаа дахин шатаах төхөөрөмж суурилуулж турших 50 сая төгрөгийн төсөвт ажил, түлшний үйлдвэрүүдэд урьдчилгаа санхүүжилт олгох гэхчлэн олон төрлийн ажлуудыг санхүүжүүлэхээс тус тус татгалзсан болно.


САНАЛ.

Нэг. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа захиалагчийн зүгээс хяналт тавихдаа ерөнхийдөө сул байна. Тухайлбал:

1.1. АББҮХ-ны 2011 оны 11/05 дугаар тогтоолын дагуу Зам, тээврийн яамны захиалгаар 2011 онд гэрээ байгуулснаар “Туртелком” ХХК-ий хэрэгжүүлж эхэлсэн нийтийн тээврийн их багтаамжийн 400 автобусыг дизель-хийн хосолмол хэрэглээнд шилжүүлэх төслийн ажил зогсонги байдалд орсон боловч захиалагч ЗТЯ цаашид хэрхэх талаар албан ёсны шийдвэрийг гаргахгүй байсаар өдий хурлээ. Энэ ажил хэрэгжсэнээр нийтийн тээврийн том оврын автобусууд дизель түлш болон шингэрүүлсэн нефтийн хийн аль алинаар нь ажиллаж шугаманд явах боломжтой болох ёстой байсан.




Нийтийн тээврийн автобус




Төхөөрөмж суурилуулж байгаа нь

1.2. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин нэрээр)-ны захиалгаар 2012 онд гэрээ байгуулж “Дашваанжил” ХХК-ий хэрэгжүүлж байгаа автомашиныг хийгээр цэнэглэх 8 станц байгуулах ажил бүрэн хэрэгжиж дуусаагүй, 4-н суурин станцыг ашиглалтад оруулсан, 4-н зөөврийн станцыг хэрхэх талаар албан ёсны шийдвэр гараагүй байна.



СХД дэх автомашин хийгээр цэнэглэх станц




Хий түгээх байгууламж

1.3. БОНХЯ-ны захиалгаар 2013 онд гэрээ байгуулж “Хаштехник” ХХК-ий хэрэгжүүлж байгаа автомашины утаа бууруулах тоног төхөөрөмж нийлүүлж суурилуулах ажлын гүйцэтгэл дутуу, ашиглагч байгууллагуудын гомдол их байгаад захиалагч дүгнэлт хийж цаашид хэрхэх талаар тодорхой шийдвэр гаргаагүй байна.



Утааны хэмжилт хийж байгаа нь



Төхөөрөмж суурилуулсан байгаа нь



Дээрх нөхцөл байдлаас шалтгаалаад Цэвэр агаарын сан 2011-2013 оны өр авлагагаа бүрэн барагдуулах боломжгүй болоод байна. Иймээс захиалагч байгууллагууд нь хяналтаа сайжруулах, холбогдох шийдвэрүүдийг нэн даруй гаргаж өгөх шаардлагатай байна.

Эдгээр зогсонги байдалтай байгаа төсөл арга хэмжээнүүдийг эцэслэх, цаашид хэрхэх талаархи асуудлыг Сайд нарын түвшинд ярилцаж шийдвэрлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна.

Хоёр. АББҮХ-ны 2014 оны 05 дугаар тогтоолын дагуу сайжруулсан түлш борлуулах ажлыг энэ галлагааны улиралд ЦАС-аас санхүүжүүлж байна. Түлш үйлдвэрлэлтийн хэмжээнээс шалтгаалж өнгөрсөн онд борлуулалт муу байсан. Энэ нь хэд хэдэн шалтгаантай. АББҮХ-ны ажлын алба түлш борлуулагчийг сонгох тендер шалгаруулалтыг оройтуулснаас гэр хорооллын иргэд өвөлжилтийн бэлтгэлээ хангаж түлээ нүүрсээ базааснаас хойно 10-р сар гаргаад сайжруулсан түлшний борлуулалт эхэлсэн. Нөгөө талаар гудамжны ам болгон дээр түүхий нүүрс зарагдаж иргэд борлуулалтын цэгийг зорин очиход төвөгшөөх магадлалтай, мөн сайжруулсан түлш нь иргэдийн талархал хүлээсэн байнгын хэрэглээ болж хэвшээгүй байна. Өнгөрсөн жилүүдэд сайжруулсан зуухны талаар иргэдэд мэдлэг мэдээлэл хангалттай түгээсэн, одоо ирэх жилд сайжруулсан түлшний чанар, үр өгөөжийн талаар сурталчилгааны ажлыг сайн хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнээс гадна түлш нийлүүлэгч, борлуулагчийн сонгон шалгаруулалтыг дулааны улиралд дуусгаж 9-р сар гэхэд захиалагч нь түлш татан авалтыг эхлүүлсэн байх шаардлагатай байна.

Гурав. Нийслэлийн Засаг дарга, харьяа агентлагуудын захиалгаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүд, ялангуяа төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн хангамж, халаалтын зуухны шинэчлэлтэй холбоотой тендер шалгаруулалтуудыг 3, 4 дүгээр саруудад багтаан явуулж, гэрээний хэрэгжилтийг галлагааны улирал эхлэхээс өмнө дуусгаж байх нь зүйтэй гэж үзэж байна.

АГААРЫН БОХИРДЛЫН ЭСРЭГ БИДНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

2011 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Цэвэр агаарын сангийн Ажлын алба байгуулагдсан ба түүнээс хойшхи 4 жил орчмын хугацаанд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн агаарын чанарын алба, Монголын Мянганы сорилтын сангийн “Цэвэр агаар” төсөл, Дэлхийн банкны санхүүжилттэй “Улаанбаатар – Цэвэр агаар” төсөл, Агаарын чанарын мэргэжлийн алба зэрэг олон байгууллагуудтай хамтран ажиллаж санхүүжүүлж хэрэгжүүлсэн олон ажлууд бий. Эдгээр олон байгууллага хамт олон, ард иргэдийн хамтын хүчин чармайлтын үр дүнг агаарын чанарын мэдээ тодорхой байдлаар илтгэнэ гэж үзэж байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Агаарын чанарын мэргэжлийн албанаас суурин харуулуудын мэдээг нэгтгэн Цэвэр агаарын санд тогтмол хүргүүлдэг. Тус мэдээнээс 2010-2015 оны галлагааны улирлын **хамгийн хүйтэн 12, 1 дүгээр саруудад** нийслэлийн агаарын бохирдол дунджаар ямар хэмжээтэй байсныг авч үзэхэд дараахь байдалтай байна. Жич: Агаарт агуулагдах бохирдуулагч бодисын агууламжийг мкг/м³ нэгжээр илэрхийлдэг.

Нарийн ширхэглэлт тоосонцор (PM2.5)-ын хэмжээ 2010 оны 12-р сараас 2011 оны 1-р сар дуустал хугацаанд стандарттаас 8,6 дахин их байсныг өнгөрсөн 2014 оны 12-р сар, 2015 оны 1-р сарын хэмжилтийн дундажтай харьцуулахад PM2.5 ойролцоогоор 2,8 дахин буурсан.



Том ширхэглэлт тоосонцор (PM10)-ын хэмжээ хамгийн ихдээ 2011 оны 12-р сараас 2012 оны 1-р сар дуустал хугацаанд стандарттаас 6,9 дахин их байсныг 2014 оны 12, 2015 оны 1-р сарын дундажтай харьцуулахад ойролцоогоор 2,75 дахин буурсан.



Хүхэрлэг хий (SO_2)-ын хэмжээ хамгийн ихдээ 2011 оны 12-р сараас 2012 оны 1-р сар дуустал хугацаанд стандарттаас 5 дахин их байсныг 2014 оны 12, 2015 оны 1-р сарын дундажтай харьцуулахад SO_2 -ын хэмжээ **1,7 дахин буурсан.**



Азотын давхар исэл (NO_2)-ын хэмжээ хамгийн ихдээ 2012 оны 12-р сараас 2013 оны 1-р сар дуустал хугацаанд стандарттаас 2,2 дахин их байсныг 2014 оны 12, 2015 оны 1-р сарын дундажтай харьцуулахад NO_2 ойролцоогоор **1,65 дахин буурсан.**






Эдгээр үзүүлэлтүүд нь нийслэл хотын 10 байрлалд орших суурин харуулуудын хэмжилтийн дунд автоматаар бүртгэгддэг юм. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд хэд хэдэн удаа зарим саруудад бага зэргийн өсөлт ажиглагдсаныг эс тооцвол агаарын бохирдол ерөнхий жингээрээ буурч байна. Хэдийгээр агаарын бохирдол буурч байгаа боловч галлагааны улиралд стандарт хэмжээнээс давсан хэвээр байгаа тул агаарын бохирдлын эсрэг хэрэгжүүлж байгаа төрөл бүрийн арга хэмжээг улам эрчимжүүлэх шаардлагатай.

ЦАС-ИЙН АЖЛЫН АЛБА

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА



ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗАДАРГАА /тэрбум төгрөгөөр/



3

2014 ОНД САНХҮҮЖУУЛСЭН САЙЖРУУЛСАН ЗУУХНЫ ТӨСЛҮҮД

	Төсөв хэрэгжүүлэгч	Зуухны нэр, төрөл	Нийлүүлсэн зуух/ширхэг	Санхүүжүүлсэн татаас/сая төг/
1	НЭДТГ	"Хүрд" ХК-ий усан халаалтын "Ич" зуух	1805	186,9
2		"Сэлэнгэ констракшн" ХХК-ий "Өлзий" зуух	5425	1144,45
3	Дэлхийн банкны Улаанбаатар Цэвэр агаар төсөл	"Роял өүшн" ХХК-ий "Дөл", "Голомт" зуух	13363	2769,8
4		"Их тэнгэрийн хүч" ХХК-ий "Векас-107" зуух	1104	152,1
5		"Том хорол" ХХК-ий "Ин-1" зуух	37	5,2
6		"Ханбаян" ХХК-ий "Номин" зуух	1	0,1
7	НЭДТГ	"Роял өүшн" ХХК-ий "Дөл" зуух	373	130,4
НИЙТ			21735	4389,0

САЙЖРУУЛСАН ТУЛШНИЙ БОРЛУУЛАЛТ

2013 ОНЫ УДАЭГДЭЛ
САНХУУЖИЛТ

- Агаарын бохирдлыг бууруулах ундаэсний хорооны 2011 оны 11/06 тогтооолын дагуу Нийслэлийн агаарын чанарын албанад **94,3 сая төгрөг** олгосон.
- Уртсан тулшиний татаасанд **24,9 сая төгрөг** олгосон.
- Агуулахын зардал **0,9 сая төгрөг** олгосон.

АББҮХ-НЫ 2014 ОНЫ 01 Р
ТОГТООСЫН ДАГУУ

- "Шарын гол энерго" ХХК, "Баялаг эрдэнэ цам" ХХК-тай гэрээ байгуулав.
- Тэдгээр компаниуд нийт **329,1 тонн тулш нийтийн** сэн. Тээвэр, борлуулалтын ажилд **15,3 сая төгрөг** олгов. Урьдчилж санхүүжүүлсэн **34,3 сая төгрөгийг** Терийн санд буцаан төвлөрүүлэв

АББҮХ-НЫ 2014 ОНЫ 05 Р
ТОГТООСЫН ДАГУУ

- АББҮХ-ны тенцэерт шалгарсан "Агмарко" ХХК-тай гэрээ байгуулсан.
- Сайжруулсан тулшийг төмөр замын өргөн дээр хуаэн авч гэр хорооллын **31 цэгт тээвэрэлэн** хүргэж борлуулсан. Ачилт, тээвэр, агуулах, борлуулалтын зардал **16,4 сая төгрөг** төлсөн.



ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛҮҮД

**Дулааны эрчим хүчиний чиглэлээр хэрэгжсэн төсөл,
олгосон санхүүжилт**

**Цахилгаан
эрчим хүчиний
чиглэлээр**

Дэнжийн 1000-ын төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээ байгуулах	Зэвсэгт хүчиний 015, 310-р агиудын зуухын барилтыг шинэчлэх	Сургууль, цэцэрлэгийн халаалтын зуухыг татан буулгаж төвлөрсөн дулаанд холбох	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгаар хэрэгжүүлсэн СБД, БЗД, ЧД-ийн 11 байрлалд АТП-ийн ачаалал хөнгөлөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажилд 954 сая төгрөг /гүйцэтгэгч 11 ААН/
НЭД-ын захиалгаар хэрэгжүүлсэн Дэнжийн 1000-ын 1-р залжийн ажлын үлдэгдэл санхүүжилт 128,5 сая төгрөг /гүйцэтгэгч "Хурд" ХК/	Батлан хамгаалах яамны захиалгаар хэрэгжүүлсэн 2013 оны гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт 91,98 сая төгрөг /гүйцэтгэгч "Жаргал констракшн" ХХК/	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгаар БГД-ийн 113-р сургуулийн гадна дулаан, ЧД-ийн 39-р сургуулийн дотор халаалтын ажилд 100,5 сая төгрөг /гүйцэтгэгч "Яруу ус" ХХК, "Зууны сод хийц" ХХК	



ХИЙН ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР

Агаарын бохирдлыг бүүрүүлах үндэсний хорооны захиалгаар шингэрүүлсэн хийн түлш нөөцийн хадгалах агуулахыг тус бур 200 м³-ээр өргөтгэх, хийн тулшиний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор гэр хорооллын 5000 өрхөд хийн плитка баллоны иж бүрдэл тараах сякыг нийт 1 тэрбум 465 сая төгрөгөөр 3 аж ахуйн нэгж хэрэгжүүлэв.



“Юнигаз” ХХК



“Горгаз” ХХК




“Дашваанжил” ХХК

7


БУСАД ТОМООХОН АЖЛУУД



Агаарын чанарын хяналт шинжилгээний чадавхийт бэхжүүлэх зорилгоор ЦУОШ-ын Байгаль орчин, хэмжлийн зүйн төв лабораторид нийт 415,6 сая төгрөгийн багаж авахад санхүүжилт олгосон



Агаарын чанарын ухаалаг хяналтын систем бий болгох сяил /3 вэб програм, 10ш ЛЭД дэлгэц модэлийн хамт/ ыг 327,5 сая төгрөгөөр санхүүжилтэй олгосон



Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тооллогын сякын санхүүжилтэд 322 сая төгрөг олгосон

8


ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

2015 оны 05-р сарын 12-ны байдлаар



9

2015 ОНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАДАРГАА/ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/



НИЙТ ТӨСӨВ 16,2 ТЭРБУМ ТӨГРЕГ


- Гэр хорооллын өрхүүдийг сайжруулсан түвшээр хангахад татаас, борлуулалтын зардал - 5.0
- Гэр хорооллын өрхүүдийг сайжруулсан зуухаар хангахад татаас, борлуулалтын зардал - 2.6
- Аймаг орон нутагт агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд санхүүжилт - 0.5
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэээр ажиллаж байгаа ААН-ийдийг дэмжих, сурталчлах 0.03
- Эрчим хүний үр ашгийг дээшлүүлэх, дулаалтыг сайжруулах, СЭХ, цэвэр технологи хөгжүүлэх - 4.4
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэээр олон нийтэд мэдлэг олгох сургалт, сурталчилгаа - 0.2
- Агаарын чанарын хяналт шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил - 2.3
- Нэг сая мод ургуулах хөдөлгөөнийг санхүүжүүлэх - 1.0
- Цэвэр агаарын сангийн дотоод зардал - 0.2

Нийт 16,2 тэрбум төгрөгийн төсвөөс 4,2 тэрбум нь өмнөх оны гэрээт ажлуудын үлдэгдэл санхүүжилт юм.

10



11



12

2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

Сайжруулсан зуухны төсөлд хамрагдсан иргэдэд татаас олгох

Нэг сая мөд ургуулах хөдөлгөөнийг санхүүжүүлэх

Гэрээний хэрэгжилт шалгах, хяналт мониторинг хийх

Хэрэгжүүлсэн бусад ажлууд

- Дэлхийн банкны санхүүжилтэй "Улаанбаатар - Цэвэр агаар" төсөлтэй хамтран хэрэгжүүлж байгаа 45000 зуухны хөтөлбөр хэрэгжжик байна. 2015 онд 8967 зуух борлогдсон.
- Өмнөх онуудад бориуусан зуухыг хасч тооцвог борлогдоогүй үлдсэн 4679 зуух байна. Тэдгээрийг галлагасаны улирал эхлээд борлуулж дуусгавал 45000 зуухны төсөл бүрэн дүүсна.
- БОНХАЖ-ын Сайдаан 2015.04.21-ний өдрийн A-181-р тушаалын дагуу БОНХАЖ-тай тэрээ байгуулан 489,7 сая төгрөгөөр санхүүжүүлсэн
- Хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зарилгоор гэр хорооллын айлүүдаа хийн плитка балмоны их бүрдэл тараасан ажлыг газар дээр нь хянаж айлүүдаар явж шалгасан
- Гэр хорооллын айл аялхүүдэд шалны халаагур нийлүүлэх ажлын хяналтыг газар дээр нь хийж айлүүдаар явж шалгасан
- ЦАС-ийн санхүүгийн бүх баримтууд, гэрээ хэлцэл, албан бичиг, тушаал шийдвэр зэргийг сканердаж электрон сан үүсгэн архивлах ажлыг хийж дуустаж байна
- Шинээн дансны хуулийг хэрэгжжик эхлэхээс бүтэн 1 жилийн өмнө бүх санхүү, гүйлгээний мэдээллийг шинээн дансны зарчимд шилжүүлсэн
- Өр авлага барагдуулах талаар анхаарч ажилласан.

ХЭРЭГЖИХ ШАТАНДАА ЯВАА АЖЛУУД

Тендер зарлагдсан ажлууд

- Нийслэлийн Засаг Даргын 2015.04.15-ны А/300-р захирамжаар 887 сая төгрөгт дулааны шутамын 4 ажлын тендер зарласан. Үндаа Баянгол 10-р хорооны 113-р сургуулийн гадна шутамын өргөтөвлө /321 сая/, Чингэлтэй 9-р хорооны 31-р цэцэрлэгийн гадна шугам /187 сая/, Хан-Уул 16-р хорооны 7-р сургуулийн гадна дотор шугам /309 сая/, Баянзүрх 8-р хорооны Алмаглан цогцол-борын гадна шугам /70 сая/

Гэрээ байгуулах шатанд

- БОНХАЖ-ны зажилгаар агаарыг бодиралыг бууруулахад чиглэсэн олон нийтэд мэдэлгэ олгох сурталчилгаанаа 200 сая төгрөг төсөвслөсөн, гэрээ байгуулагдаж байна.
- Агаарыг бодирал хувцэх дээд хэмжээнээс хэтэрсэн 5 аймарт нийт 500 сая төгрөгийн санхүүжилт олгох гэрээний төслийг БОНХАЖ-на хүргүүлсэн, хянагдаж байна.

Бусад

- Агаарын чанарыг сайжруулах бусэд айл аялгийг цахилгаанаар халаах боломжийг нэмэгдүүлэхийн тулд цахилгаан хонгамж сайжруулах нийт 2 тэрбум төгрөгийн төсвээ ажлуудын хувьд НЭД-ын захирамж гарах, тендер шалгаруулалтын бэлтгэл ажих НЭДТГ дээр хийгдэж байна.
- Агаарын чанарын суурин харуулын тоог нэмэгдүүлэх багаж төхөөрөмж нийлүүлэх 1,65 тэрбум төгрөгийн ажлын тендер БОНХАЖ зарлах бэлтгэл хийгдэж байна.

БУСАД АЖЛУУД

МОНГОЛ УИШИГ
ЧИМЗИЙН АУДИТИЙН ГҮРҮН
ЧИМЗИЙН АУДИТИЙН ГҮРҮН
ЧИМЗИЙН АУДИТИЙН ГҮРҮН

Аудитын төслийн
хүснэгт

Төслийн төслийн 15 дугаар төслийн 1 ч Төслийн төслийн
8 дугаар төслийн 15-д залжсан дараа Сонир агаарын 2014 оны 12 дунд
жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан, замчилж
идээ дэлжин тутамж, шанд нарийнчилэн ижилж, хамгийн чуулганы
төслийн төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан
төслийн төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан

Тусдаа хөгжлийн төслийн төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан

Төслийн төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан

Санжүүтийн төслийн төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан

Санжүүтийн төслийн төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан

Санжүүтийн төслийн төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан

Санжүүтийн төслийн төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан

Зөвлөхийн санал дүүрэг

Цэвэр агаарын 2014 оны 12 дунд жилийн 31-ний хөхөрөгт санжүүтийн
бодлогын төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан
төслийн төслийн 15 дунд жилийн 31-ний өндөр дүүрэг болгононгой зорилтуулж байсан


САНЖҮҮТИЙН АУДИТИЙН ГҮРҮН
ДАЧАА ЧИМЗИЙН АУДИТИЙН ГҮРҮН

2015 оны 2-3 дугаар
саруудад үндэсний
аудитын газраас
хийсэн шалгалтад
хамрагдаж
“Зөрчилгүй” санал
дүгнэлт авсан.

2015 оны 2-р сарын
10-ний өдөр Цэвэр
агаарын сангийн
Удирдах зөвлөлийн
хурлыг хийлгэж 2014
оны ажлаа
дүгнүүлэн 2015 оны
төсвийн төлөвлөгөөг
батлууллаа.

15

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА



ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН АЖЛЫН АЛБА

16